

## ЕРӨНХИЙ ЭРХЛЭГЧИЙН ЗУРВАС

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн 55 жилийн ойн хүрээнд эрхлэн гаргаж буй “Олон улс судлал” сэтгүүлийн ээлжит 116 дахь дугаараа уншигч Таны гарт өргөн барьж байгаадаа баяртай байна. ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн эрдэм шинжилгээний сэтгүүлүүдийг EBSCO-д индекс хийгдэх гэрээ шинэчлэгдэж, “Олон улс судлал» эрдэм шинжилгээний сэтгүүл нь DOAJ (Directory of Open Access Journals)-д бүртгүүлсэн тус хүрээлэнгийн хоёр дахь сэтгүүл болсон амжилттай 2023 оныг үдэж байгааг эрхэм уншигчид та бүхэндээ дуулгахдаа таатай байна.<sup>1</sup>

Сүүлийн жилүүдэд “Олон улс судлал” сэтгүүл уламжлалт цаасан суурьтайгаар хэвлэгдэхийн зэрэгцээ тогтмол цахим хувилбараар уншигч олонд хүрдэг болсон билээ. Ингэснээр сэтгүүлийн хүртээмж сайжирч, цахим орчин дахь хандалтын үзүүлэлт эрс нэмэгдэн өгүүллээ нийтлүүлэх хүсэлтэй судлаачид болон өргөн олон уншигчдын анхаарал сонирхлыг улам ихээр татах болоод байна. Тухайлбал, манай

сэтгүүлийн [www.imori.ac.mn](http://www.imori.ac.mn), [www.mongoliajol.info/index.php/JIS](http://www.mongoliajol.info/index.php/JIS) цахим хуудаснаа буй нийт бүтээлийг зөвхөн 2023 онд 57 мянга гаруй удаа татан авч ашигласан тоон үзүүлэлт байна.

2023 онд манай сэтгүүлийн редакц гадаад, дотоодын эрдэмтэн судлаачдаас ирүүлсэн 20 гаруй эрдэм шинжилгээний өгүүлэлд хөндлөнгийн хянан магадалгааг тус бүр хоёр удаа хийж, 2023 оны хоёр дахь дугаартаа дөрвөн өгүүллийг сонгон авч та бүхэнд хүргэж байна. Энэ удаагийн дугаарт Монгол Улс ба хөрш хоёр орны харилцаа болон “гуравдагч хөрш”-ийн харилцаатай холбогдох асуудлаарх өгүүллүүд болон Монгол Улсын гадаад бодлогын өөрчлөлт, хувьсал, Монгол Улс дахь олон улс судлалын чиг хандлагыг дүгнэсэн нийтлэлүүд багтсан болно. Тухайлбал, БНХАУ-ын “Нэг бүс, Нэг зам” санаачилгын 10 жилийн ойн хүрээнд ШУА-ийн Философийн хүрээлэнгийн Улс төр, эрх зүйн салбарын эрдэм шинжилгээний ажилтан, доктор Ойдовын Хатанболдын бичсэн “Нэг бүс Нэг зам санаачилга

<sup>1</sup> DOAJ нь дэлхийн өнцөг булан бүрд гарч буй эрдэм шинжилгээний нээлттэй сэтгүүлүүдийн (open access) -ийн албан ёсны бүртгэл бөгөөд чанартай агуулгуудыг нээлттэйгээр хүн бүрд хүргэх зорилготой олон улсын өргөн хүрээтэй санаачилга билээ. Одоогоор DOAJ бүртгэлд дэлхийн 133 орны 19603 эрдэм шинжилгээний сэтгүүл бүртгэлтэй байна. Дашрамд сонирхуулахад DOAJ-д Монгол Улсаас өнөөгийн байдлаар 7 эрдэм шинжилгээний сэтгүүл бүртгэгдсэн байгаа бөгөөд үүнээс 6 нь #MongoliaJOL платформын эрдэм шинжилгээний сэтгүүлүүд байна. <https://doaj.org/toc/2663-7871>

ба Монгол Улс: Шинжээчдийн судалгааны үр дүн” өгүүллийг онцолж байна. Тэр бээр өгүүлэлдээ БНХАУ-аас дэвшүүлсэн уг санаачилга дахь Монгол Улсын оролцоо, түүний үр өгөөж, өнөөгийн нийгмийн амьдралд үзүүлж буй тусгал хийгээд тулгарч буй саад бэрхшээл, гарц шийдлийг тодруулахын тулд 30 гаруй өндөр түвшний шинжээчдийн дунд тусгайлан бэлтгэсэн шинжээчийн асуулгаар “Google Form” платформыг ашиглан 60 орчим шинжээчээс цахимаар судалгааг цуглуулж, асуулт тус бүрээр нэгтгэн боловсруулсан сонирхолтой үр дүнг танилцуулжээ.

Монгол Улс Зүүн хойд Азийн бүс нутаг дахь хамгийн ойрын “гуравдагч хөрш”-ийн нэг Япон Улстай Эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг 2016 онд байгуулан хэрэгжүүлж буй. 2023 оны эцэст БНСУ-тай уг хэлэлцээрийг байгуулахаар тохиролцож, албан ёсны хэлэлцээг эхлүүлсэн. Энэ чиглэлд хөндөгдөж буй нэн чухал асуудал болох гаалийн тарифын хэлэлцээг хийхэд манай улсын талаас анхаарах шаардлагатай зүйлсийг тодруулах зорилгоор БНСУ-ын зүгээс бусад оронтой ийм хэлэлцээр байгуулсан туршлагыг судалж, Монгол Улсаас БНСУ-д санал болгох тарифын хөнгөлөлтийн жагсаалтыг хүргүүлэхэд шаардагдах харьцангуй давуу талын судалгааг Монгол Улсын Их Сургуулийн Бизнесийн сургуулийн багш, доктор Нямдаагийн Отгонсайхан, доктор Өлзий-Очирын Номинцэцэг болон магистрант Энхтуяагийн

Дэлгэржаргал нар “Монгол Улс, Бүгд Найрамдах Солонгос Улс хоорондын эдийн засгийн түншлэлийн хэлэлцээр: Гаалийн тарифын хэлэлцээ хийхэд анхаарах зарим асуудал” өгүүлэлдээ бичсэнийг мөн онцолж байна.

Мөн энэ удаагийн дугаарт Монгол-Хятадын эдийн засгийн харилцааны асуудлаар нэгэн сонирхолтой өгүүлэл нийтлэгдсэн нь Монгол Улсын Их Сургуулийн Улс төр, олон улсын харилцаа, нийтийн удирдлагын сургуулийн багш, доктор Заанаагийн Өлзий, Батмөнхийн Мөнх-Өлзий нарын “Монгол-Хятадын хилийн боомтын цар тахлын үеийн үйл ажиллагаа: Замын-Үүд боомтын гео-эдийн засгийн жишээн дээр” өгүүлэл болно. Тус өгүүлэлд “ковид-19” цар тахлаас үүдэн хоёр талын худалдаа, эдийн засгийн харилцаанд үүссэн хүндрэл бэрхшээлийг тодорхойлохын зэрэгцээ хоёр орны худалдаа, эдийн засгийн харилцааны стратегийн ач холбогдолтой гол суваг Замын-Үүд боомтын үйл ажиллагаанд цар тахлын үзүүлсэн нөлөөг дүгнэж, ийм төрлийн болзошгүй хямралыг цаашид хэрхэн даван туулах тухайд судлаачид өөрийн байр суурь, тодорхой саналуудыг дэвшүүлжээ.

ШУА-ийн Олон улс судлалын хүрээлэнгийн Орос судлалын салбарын эрдэм шинжилгээний тэргүүлэх ажилтан, доктор Адъяагийн Нямдолжин “Монгол-Оросын хооронд байгуулсан гэрээ хэлэлцээрүүдийн зарим асуудлуудад хийсэн дүн шинжилгээ” өгүүлэлдээ Монгол-

Оросын харилцааны эрх зүйн суурь баримт бичгүүд, тухайлбал, 1993 оны “Монгол Улс, ОХУ-ын найрсаг харилцаа, хамтын ажиллагааны тухай гэрээ”, 2000 оны “Улаанбаатарын тунхаглал”, 2006 оны Москвагийн тунхаглал, 2009 оны “Монгол Улс, ОХУ-ын хооронд Стратегийн түншлэл хөгжүүлэх тухай тунхаглал”, 2019 оны “Найрсаг харилцаа, иж бүрэн стратегийн түншлэлийн тухай Монгол Улс, ОХУ-ын хоорондын гэрээ” зэрэг баримт бичгүүд болоод бусад гэрээ хэлэлцээрүүдэд дүн шинжилгээ хийх замаар хоёр орны улс төр, эдийн засгийн харилцаанд тулгамдсан асуудлуудыг судлан шинжилсэн байна.

Манай хүрээлэнгийн 55 жилийн ой тохиосон 2023 онд сэтгүүлийн Ерөнхий эрхлэгч миний бие байгууллагынхаа түүхэн хугацаан дахь судалгааны гол үр дүнг нэгтгэн тоймлож, хүрээлэн дэх олон улс судлалын судалгааны өнөөгийн байдал, цаашдын төлөвийн талаар дүгнэлт, саналаа танилцуулсан нийтлэлийг энэ удаагийн дугаартаа толилуулж байна.

Манай сэтгүүлийн “Нийтлэл” хэсэгт гадаад бодлогын судлаач, профессор, Онц бөгөөд Бүрэн эрхт

Элчин сайд Д.Баярхүү Монгол Улсын гадаад бодлого ардчилал, шинэчлэлийн 33 жилд хэрхэн хувьсан өөрчлөгдсөн, ямар үр дүнд хүрсэн тухай зургаан Ерөнхийлөгчийн үйл ажиллагаанд тулгуурлан дүгнэснийг “Монгол Улсын гадаад бодлогын шинэчлэл” нийтлэлээс үзэх болно.

Энэхүү дугаарт өгүүллээ нийтлүүлсэн эрдэмтэн судлаачид болон үнэт цаг заваа харамгүй зориулан бодит шүүмжийг ирүүлсэн нийт шинжээч эрдэмтэд, Редакцын зөвлөлийн гишүүдэд Ерөнхий редакторын хувьд гүн талархал илэрхийлж байгаагаа үүгээр уламжилъя.

“Олон улс судлал” сэтгүүлийн 2024 оны дугаарт эрдэм шинжилгээний өгүүллээ хэвлүүлэх хүсэлтэй эрдэмтэн судлаач Та бүхэн <https://mongoliajol.info/index/user/register> хуудсанд өөрийн нэрээр эрх үүсгэн бүртгүүлж, судалгааны бүтээлээ илгээж болохын зэрэгцээ сэтгүүлийн талаарх санал, сэтгэгдлээ [mjis@mas.ac.mn](mailto:mjis@mas.ac.mn) цахим шуудангаар ирүүлбэл бид хэзээд талархан хүлээн авах болно.

*Ерөнхий эрхлэгч*